

ХАМТРАН ЗЭЭЛ АВАХ, ЗЭЭЛИЙГ ЭРГЭН ТӨЛӨХ ТУХАЙ ГЭРЭЭ

..... оны ... дугаар
сарын-ний өдөр

Улаанбаатар
хот

Нэг талаас: “.....” ХХК-ийг төлөөлж, Ерөнхий захирал /РД:, /цаашид “А тал” гэх/,

нөгөө талаас: “.....” ХХК-ийг төлөөлж, Ерөнхий захирал /РД:, /цаашид “Б тал”, хамтад нь “Талууд” гэх/ нар доорх нөхцөлөөр харилцан тохиролцож, энэхүү “Хамтран зээл авах, зээлийг эргэн төлөх тухай гэрээ” /цаашид “Гэрээ” гэх/-г байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү гэрээгээр “А тал” нь өөрийн нэр дээр “.....” /цаашид “Банк” гэх/-наас зориулалттай, төгрөгийн зээл авах, банкны барьцаанд “Б тал”-ын өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийг “Зээлийн гэрээ”-ний үүргийн гүйцэтгэлд барьцаалуулах, банкнаас олгосон зээлээс тохиролцсон хэмжээгээр хуваарилах, талууд тус бүр өөрт ноогдох хэсгээр зээл, түүний хүүг хугацаанд нь, бүрэн төлж барагдуулахтай холбогдон талуудын хооронд үүсэх эрх зүйн харилцааг зохицуулна.
- 1.2 Талууд тус бүр банкнаас зээл авах харилцаанд дараах үүрэгтэйгээр оролцоно. Үүнд:
 - 1.2.1 “А тал” нь банкнаас зээл хүсэх асуудлыг бүхэлд нь хариуцах, банкнаас тавьсан шаардлагыг бүрэн хангаж, зохих баримт бичгийг бүрдүүлэх, гэрээ хэлцэл байгуулах;
 - 1.2.2 “Б тал” нь Улсын бүртгэлийн дугаарт бүртгэгдсэн, тоот гэрчилгээний дугаар бүхий, дүүрэг, дүгээр хороо, ... дүгээр хороолол гудамж, тоот хаягт байрлах, м.кв талбай бүхий оффисын зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг “Зээлийн гэрээ”-ний үүргийн гүйцэтгэлд барьцаалуулах.
- 1.3

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Энэхүү гэрээг 20... оны дугаар сарын ...-ны өдөр байгуулсан ба талууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.
- 2.2

Гурав. Баталгаа, мэдэгдэл

- 3.1 Талууд гэрээний дагуу дараах баталгаа, мэдэгдлийг гаргаж буй болно. Үүнд:
 - 3.1.1 “А тал” нь банкнаас зээл хүсэхэд тавигдах шаардлагыг хангаж буй бөгөөд зээл, түүний хүүгийн эргэн төлөлтийг тогтоосон хугацаанд, бүрэн төлж барагдуулах санхүүгийн чадвартай, тогтвортой бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг болохыг;
 - 3.1.2 “А тал” нь өөрийн зүгээс төлбөл зохих зээл, түүний хүүгийн төлбөрийг цаг хугацаанд нь, бүрэн төлж, “Б тал”-ын өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийг банкны барьцаанаас чөлөөлүүлэх болохыг;
 - 3.1.3
- 3.2 Талууд банкнаас олгосон зээлээс тохиролцсон хэмжээгээр хуваарилан авч, өөрт ноогдох зээлийн эргэн төлөлтийг “Зээлийн гэрээ”-нд тусгасан графикт хуваарийн дагуу бүрэн төлж, барагдуулах ба ийнхүү хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд үүнтэй



холбогдон үүсэх хариуцлагыг буруутай тал нь бүрэн хүлээх болохыг үүгээр хүлээн зөвшөөрч байгаа болно.

Дөрөв. Зээл, түүнийг хуваарилах, төлөх

Зээл, түүнийг хуваарилах:

4.1 Талууд энэхүү гэрээг байгуулсны үндсэн дээр банкнаас олгох зээлээс талуудын хуваарилан авах хувь, хэмжээг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

4.1.1 “А тал” нь “..... банк”-наас талуудад харилцан ашигтай зээл авах асуудлыг бүрэн хариуцаж буй тул /...../ төгрөгийг өөрт хуваарилан авах;

4.1.2 “Б тал” нь өөрийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийг “Зээлийн гэрээ”-ний үүргийн гүйцэтгэлд барьцаалуулж байгаа тул банкнаас олгогдох зээлээс /..... сая/ төгрөгийг хуваарилан авахаар талууд харилцан тохиролцов.

4.2

Үргэлжлэл бий /5х/

